

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**


2019 оны 06 дугаар сарын 10

Багануур дүүрэг

| № | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Шалгуур үзүүлэлт | 2019 онд хүрэх түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь | Үнэлгээний хувь |
|--|---|---|----------------------|---------------------------------|-------------------------------|-------------------|-----------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ | | | | | | | |
| Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр: | | | | | | | |
| 21 | 1.10. Багануур үйлдвэрлэл, технологийн парк-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | <p>1.10.1. Үйлдвэрлэл, технологийн парк ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <ol style="list-style-type: none"> Ерөнхий төлөвлөлтийг БХБЯ-ны шийдвэрээр Нийслэлийн ИТХ-р хэлэлцүүлэхээр Мон-Энержи компани нь нийслэлийн барилга төлөвлөлтийн газарт материалыг хүргүүлээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хийгдэх арга хэмжээнд Паркийн цахилгаан хангамжийн ө.х шугам дэд станц барих болон хүнд ба хөнгөн үйлдвэрлэлийн бүсүүдийн дэд бүтцийг байгуулах төслийн хөрөнгийг тусгуулахаар саналыг БХБЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ, ЭХЯ-дад хүргүүлсэн. Мон-Энержи ХХК нь холбоо, дулаан, цэвэр бохир усны зураг төсөлд хангагч байгууллагуудаас санал авах арга хэмжээ авч, хот хоорондын төв магистрал шугам, уурхай хүртэлх засмал зам, төмөр замын хөндлөн огтлох замуудын трасст холбогдох байгууллагуудаас саналыг авч байна. БХБЯ нь ХХААХҮЯ-аас өмнөх ТЭЗҮ-ийг авч цахилгаан хангамжтай холбоотой материалыг ЭХЯ-д хүргүүлж, техникийн нөхцөл авах талаар тоот явуулж шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна. | БҮТП ОНӨТҮГ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 10% | 5% | |

| | | | | | | | |
|---|---|---|-------------------------------|---------------------------------|------|-----|--|
| 22 | 1.11. Эдийн засгийн үр ашигтай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана. | 1.11.1. Шинээр үйлдвэр байгуулах гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, мэдээллээр хангаж ажиллана. | ДБҮҮХ, БҮТП ОНӨТҮГ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 50% | 25% | |
| | | <p>Үндэсний хөгжлийн газар болон GIZ ЭТИС хөтөлбөр хамтран “Жижиг, дунд бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Залуу эрдэмтэд, гарааны бизнесийн инновациудыг дэмжих сан”, “Бүтээлч сэтгэлгээ, медиа болон цахимжуулалтын төрлийн инновациудыг дэмжих сан” байгуулсан бөгөөд эдгээр сангуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд 45 сая төгрөг хүртэлх буцалтгүй хөрөнгө оруулалт хийх төсөл сонгон шалгаруулалтад БҮТП-аас 5 төслийг оролцуулснаас эхний шалгаруулалтад дараах төслүүд тэнцсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар компост бордоо хийх үйлдвэр • Багануурын нүүрсний уурхайн овоолгын шорооноос будаг гаргах үйлдвэр <p>Шалгарсан 2 төслийг Инновацийн сангаас гаргасан зааврын дагуу шинэчлэн боловсруулж хоёрдугаар шатны шалгаруулалтад 2019.04.23-ны өдөр хүргүүлсэн. Одоогоор төслийн шалгаруулалтын эцсийн дүн гараагүй байна.</p> | | | | | |
| ГУРАВ. БАЯЛАГ БҮТЭЭГЧДЭЭ ДЭМЖСЭН, ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖСӨН ХОТ | | | | | | | |
| 133 | 3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд нано технологи, аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, томоохон болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана. | 3.1.1. Монхимо ХХК-ний Адуу брэндийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах ажлыг бодлогоор дэмжинэ. | БҮТП ОНӨТҮГ Монхимо ХХК | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 50% | |
| | | <ol style="list-style-type: none"> 1. Паркийн нэгж Монхимо ХХК нь Оросын холбооны улсад бүтээгдэхүүн экспортлох албан ёсны зөвшөөрлүүдийг хүлээн авч үйлдвэрлэлийн өргөтгөлийн ажилд бэлтгэж байна. 2. Ерөнхий сайд болон салбарын сайдуудыг Багануур дүүрэгт ажиллах хугацаанд Монхимо ХХК-ийн “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-т батлагдсан “Адуу” брэндийн үйлдвэрлэлийн өргөтгөлд шаардлагатай 5,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар асуудлыг танилцуулсан. | | | | | |
| 151 | 3.10. Гадаадын хөрөнгө оруулалттай, | 3.11. Гадаадын хөрөнгө оруулалттай, орчин үеийн | БҮТП ОНӨТҮГ | Үйл ажиллагааны | | | |

| | | | | | | | |
|--|---|---|--|-----------------|-----|-----|--|
| | орчин үеийн дэвшилтэт технологи бүхий ноос гүн боловсруулах эко үйлдвэрийн ажлыг дэмжиж эхлүүлнэ. | дэвшилтэт технологи бүхий ноос гүн боловсруулах эко үйлдвэрийн ажлыг дэмжиж эхлүүлнэ. | | хэрэгжилт, хувь | 30% | 0% | |
| | | Япон улсын хөрөнгө оруулагч Силк Роуд Аёори Япон ХХК, Дүүргийн Засаг дарга, Салбарын яам болон БҮТП-ийн байгуулсан "Ноос, ноолуур гүн боловсруулах" үйлдвэрийн Санамж бичгийн хүрээнд паркийн зүгээс шаардлагатай бүх мэдээллээр ханган дэмжиж ажилласан. Энэ оны хагас жилийн байдлаар төсөл хэрэгжүүлэгч Силк Роуд Аёори Монгол ХХК нь үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл ирүүлээгүй байна. | | | | | |
| | | Дундаж хувь | | | | 20% | |



ТАЙЛАН ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА *[Signature]* Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН НЭПТГЭСЭН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *[Signature]* Б.МИЧИД-ЭРДЭНЭ